



ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 10 сарын 10 өдөр

Дугаар А/595

Эрдэнэт

Сургалт явуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 29 дүгээр зүйлийн 1.6 /а/, 29.2 дахь заалт, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.6 дахь заалт, Дайчилгааны тухай тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1.3 дахь заалт, 2017 оны цэргийн сургалт бэлтгэлийн үндсэн арга хэмжээний төлөвлөгөөг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг.Багийн Засаг дарга нартай цэргийн бэлтгэл сургалтыг 2017 оны 10 дугаар сарын 25-28-ны хооронд 3 хоног, дайчилгаа удирдах томилгоот бүлгийн сургалтыг 10 дугаар сарын 24-ний өдөр 8 цагийн хугацаатай зохион байгуулж явуулахыг Цэргийн штабын дарга хурандаа Г.Батсуурьт даалгасугай.

Хоёр.Сургалт, багийн Засаг дарга нарын цэргийн хувцас, хэрэглэлд шаардагдах 4843200 /Дөрвөн сая найман зуун дөчин гурван мянга хоёр зуун /төгрөгийг Засгийн газрын 2016 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 215 дугаар тогтоолын дагуу цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөрийн 2017 оны орлогын орон нутагт үлдэх хэсгээс гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.



Д.БАТЛУТ

Аймгийн Засаг даргын 2017 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 4 дугаар захирамжийн хавсралт

**БАГИЙН ЗАСАГ ДАРГА НАРЫН СУРГАЛТАНД
ШААРДАГДАХ ТӨСВИЙН ТООЦОО**

№	Зардлын нэр	Тоо хэмжээ	Нэгж	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1. Хоол, цай ундааны зардал					
1.	Хоол /2017 оны 10 дугаар сарын 25, 26, 27 /	28	3 хоног	6000	504000
2.	Хоол /2017 оны 10 дугаар сарын 24-нд/	32	1 хоног	6000	192000
Бүгд					696000
2. Хувцасны зардал					
	Цэргийн зуны хээрийн хувцас	30 хос		120000	3600000
	Цэргийн зуны хээрийн малгай	30 ширхэг		15000	450000
Бүгд					4050000
3. Тээврийн зардал					
1.	Бие бүрэлдэхүүнийг тээвэрлэх	A-92	60	1620	97200
Бүгд					97200
Нийт					4843200